



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/27

Ховд

Агуулахын газрын байнгын  
байршил тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн “г” дахь заалт, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Талс молор” ХХК-нд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хадгалах агуулахын газрын байнгын байршлыг Алтай сумын Бодонч багийн Оцог хад хэмээх газарт тогтоож, тухайн газрын солбицлуудлыг хавсралтаар баталсугай.

2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хадгалах агуулахын байранд “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” болон бусад холбогдох хууль, журмын хүрээнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга П.Эрдэнэчулуунд даалгасугай.

3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хадгалах агуулахын байранд “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг баримталж, холбогдох газруудад тайлан мэдээг хүргүүлж, агуулахын газрын байнгын байршлыг мэдээллийн нэгдсэн санд хуулийн хугацаанд бүртгүүлэхийг “Талст молор” ХХК-ний захирал Б.Мөнхтөрд даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповронд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/27 Ch

02 00055

Аймгийн Засаг даргын 2020 оны  
01 дүгээр сарын 21-ний өдрийн  
А/27 дугаар захирамжийн хавсралт

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙГ  
ХАДГАЛАХ АГУУЛАХЫН ГАЗРЫН БАЙНГЫН БАЙРШИЛ

№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	92	17	53,396	46	19	18,982
2	92	17	56,673	46	19	21,293
3	92	18	0,009	46	19	19,023
4	92	17	56,731	46	19	16,712

-oOo-